



ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТЫН ХУРААНГУЙ ТАЙЛАН

**“ЭРҮҮЛ МЭНДИЙН ДААТГАЛ, ҮР ДҮНД СУУРИЛСАН
САНХҮҮЖИЛТИЙН ТОГТОЛЦОО, ҮР НӨЛӨӨ”**

Үр дүнд суурилсан санхүүжилтийн тогтолцоо бүрдсэнээр
ЭМБ-ын үзүүлэх тусламж, үйлчилгээ, санхүүжилт нэмэгдсэн ч
төлбөрийн нэхэмжлэлийн шаардлага хангагдахгүй байгаагаас үйл
ажиллагаа хэвийн явагдах нөхцөл бүрдэхгүй байна.

Аудитын код: ДГА-2023/19-8-ШТА-ГА

Цахим хуудас:

www.audit.mn

Дорноговь аймаг

2023 оны 05 сар

Дарга, тэргүүлэх аудитор: Т.Ган-Өлзий

Утас: 70522734

Аудитын менежер:

Утас: 70523020

Ахлах аудитор:

Аудитор:

Цахим хаяг: dornogovi@audit.gov.mn

У.Оюунтүлхүүр

Цахим хаяг: oyuntulkhuur.u@audit.gov.mn

Э.Энхцэцэг

Цахим хаяг: enkhtsetsege@audit.gov.mn

Б.Ариунбаатар

Цахим хаяг: ariunbaatarb@audit.gov.mn

1. Ерөнхий мэдээлэл:

Аудитын сэдэв: “Эрүүл мэндийн даатгал, үр дүнд суурилсан санхүүжилтийн тогтолцоо, үр нөлөө” сэдэвт гүйцэтгэлийн аудит хийж, дүгнэлт гарган, зөвлөмж боловсруулж, дүнг холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулахад аудитын зорилго чиглэгдсэн.

Аудитын зорилгыг хангахын тулд дараах дэд зорилтын хүрээнд аудитыг гүйцэтгэлээ. Үүнд:

1. Эрүүл мэндийн даатгалын тогтолцоо, үйл ажиллагааны үр дүн, төрөөс баримтлах бодлогын баримт бичгийн хэрэгжилт хангагдсан эсэх;
2. Эрүүл мэндийн байгууллагаас даатгуулагчийн эрэлт, хэрэгцээ шаардлагад нийцсэн эрүүл мэндийн чанартай тусламж үйлчилгээг үзүүлж байгаа эсэх;

Аудитын хамарсан хүрээ: Аудитад аймгийн ИТХ, ЗДТГ, ЗДТГ-ын нийгмийн бодлогын хэлтэс, хяналт шинжилгээ үнэлгээний хэлтэс, Эрүүл мэндийн газар, Эрүүл мэндийн даатгалын хэлтэс, Нийгмийн даатгалын хэлтэс, эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлэгч төрийн болон хувийн хэвшлийн байгууллагууд, өрх, сумдын эрүүл мэндийн төвийн 2021, 2022 оны үйл ажиллагааг хамруулсан.

Арга зүй: Аудитыг АДБОУБ (INTOSAI)-ын Стандартын хорооноос баталсан АДБОУС-100, АДБОУС-300, АДБОУС-3000-д нийцүүлэн баталсан Монгол Улсын Төрийн аудитын стандарт MNS 6817-1:2020 “Төрийн аудит. Тулгуур зарчим”, MNS 6817-5:2020 “Төрийн аудит. Гүйцэтгэлийн аудитын тулгуур зарчим”, MNS 6817-7:2020 “Төрийн аудит. Гүйцэтгэлийн аудит”, MNS 6817-8:2020 “Төрийн аудит. Нийцлийн аудит”-ын стандартад заасан зарчим, арга зүйд нийцүүлэн, Монгол Улсын Ерөнхий аудиторов баталсан Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам (2020 он), “Гүйцэтгэлийн аудитын заавар, аргачлал”-ын дагуу холбогдох албан тушаалтнуудтай ярилцлага хийх, асуулга лавлагаа, тодруулга болон судалгаа авах, харьцуулах, нэгтгэх, дүн шинжилгээ хийх зэрэг арга зүйг ашиглан аудитын хөтөлбөр, горим, асуудлын шинжилгээний дагуу нотлох зүйл цуглуулж, аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж боловсрууллаа.

Аудитын шалгуур үзүүлэлт: Аудитад асуудлын шинжилгээний асуултын дагуу нарийвчлан боловсруулсан аудитын арга зүйтэй холбоотой дараах хууль, эрх зүйн актын холбогдох заалтыг шалгуур үзүүлэлт болгон ашиглав. Үүнд:

- Төрийн хэмнэлтийн тухай хууль, 2021 оны төсвийн тухай хууль, 2022 оны төсвийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, ТБОНӨХБАҮХАТ хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Шилэн дансны тухай хууль, Эрүүл мэндийн тухай хууль, ЭМД-ын тухай хууль, Эмнэлгийн тусламж, үйлчилгээний тухай хууль, Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хууль, МУ-ын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030”, Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого /УИХ-ын 2016 оны 19 дүгээр тогтоол, МУ-ын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр батлах тухай /УИХ-ын 2020 оны 24 дүгээр тогтоол/, “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, МУ-ын урт хугацааны хөгжлийн бодлогын хүрээнд 2021-2030 онд хэрэгжүүлэх үйл ажиллагаа”, МУ-ын урт хугацааны хөгжлийн бодлогын хяналт, шинжилгээ, үнэлгээний шалгуур үзүүлэлт, хүрэх түвшин” /УИХ-ын 2020 оны 52 дугаар тогтоол/, Эрүүл мэндийн салбарын хөгжлийн дунд хугацааны төлөвлөгөө /2021-2030 он/, ЭМД-ын Үндэсний зөвлөлийн тогтоолууд, ЭМДЕГ-ын тушаалууд, холбогдох бусад хууль тогтоомж, эрхзүйн актууд.

Аудит хийсэн баг, албан тушаалтан: Аудитыг Дорноговь аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Т.Ган-Өлзий удирдаж, аудитын менежер У.Оюунтүлхүүр аудитын үе шатны чанарын хяналтыг хэрэгжүүлэн, ахлах аудитор Э.Энхцэцэг, аудитор Б.Ариунбаатар нар гүйцэтгэв.

2. Аудитын үр дүн:

А. ЭМД-ын талаар төрөөс баримтлах бодлого чиглэлийг орон нутгийн бодлогод тусгаж, хэрэгжилтийг хангаж ажилласан байна.

Үндэсний урт, дунд, богино хугацааны бодлогын баримт бичигт тусгагдсан арга хэмжээг орон нутгийн бодлогын баримт бичигт тусган баталж, Дорноговь аймгийн 2021-2025 онд хөгжүүлэх 5 жилийн үндсэн чиглэлд 2, аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр /2020-2024/-т 4, аймгийн 2021 оны жилийн хөгжлийн төлөвлөгөөнд 3, 2022 оны жилийн хөгжлийн төлөвлөгөөнд 6, нийт 15 арга хэмжээг хэрэгжүүлэхээр тусгаж, хэрэгжилтийг холбогдох журмын дагуу баримт бичиг тус бүрээр үнэлж дүгнэсэн байна.

Б. Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний зардлын төлбөрийг гүйцэтгэлээр олгож байгаа нь даатгуулагчийн хэрэгцээнд нийцсэн тусламж, үйлчилгээ үзүүлэхэд сөргөөр нөлөөлж байна.

ЭМДС-ийн орлогыг 2019-2021 онуудад дунджаар 15-28 хувиар нэмэгдүүлэн төлөвлөж, гүйцэтгэл 10-20 хувиар өссөн байхад 2022 оны орлогыг өмнөх оноос 101.7 хувиар нэмэгдүүлэн төлөвлөснөөс орлогын төлөвлөгөө 69.3 хувьтай хэрэгжиж, төлөвлөгөө 4,465.7 сая төгрөгөөр тасарсан байна.


ЭМДС-ийн орлогын төлөвлөгөө, гүйцэтгэл

/сая төгрөг/

2021 он				2022 он			
Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Хэрэгжилтийн хувь	Авлагын үлдэгдэл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Хэрэгжилтийн хувь	Авлагын үлдэгдэл
7,216.5	8,603.7	119.2	350.0	14,558.6	10,092.9	69.3	370.2

Эх сурвалж: Аймгийн НДХ-ийн НДС-ийн санхүүгийн тайлан

ЭМДЕГ-ын даргын 2021 оны А/10, 2022 оны А/13 тушаалаар малчид, оюутан суралцагчид, тодорхой хөдөлмөр эрхлээгүй иргэд, гадаадын иргэн, харьяалалгүй иргэдийн эрүүл мэндийн даатгалын хамралтын төлөвлөгөөг баталсан ба төлөвлөгөө, гүйцэтгэлийг харьцуулахад 2021 оны хэрэгжилт 41.0 хувь, 2022 онд 49.5 хувьтай, төлөвлөгөө 50.5-51.0 хувиар тасарсан байна.



Нийгмийн даатгалд даатгуулагчийн судалгаа

/сая төгрөг/

Үзүүлэлт	2021 он	2022 он	Нийт мөнгөн дүн
Албан журмын даатгуулагчийн тоо	18,970	20,529	-
Сайн дураар даатгуулсан иргэдийн тоо	6,872	3,593	690.7
НД-д даатгуулагчийн дүн	25,842	24,122	690.7

Аймгийн НДХ-ийн тайлангийн тоон үзүүлэлтээс харахад аудитад хамрагдсан хугацаанд 10,465 иргэн сайн дураар даатгуулсан боловч Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн 4.2, Нийгмийн даатгалын тухай хуулийн 4.3 дахь заалтуудын уялдаагүй байдлаас шалтгаалж ЭМДС-д нийт 690.7 сая төгрөгийн орлого төвлөрүүлэх боломж алдагдсан байна.

Дорноговь аймгийн ЭМДХ нь ЭМДҮЗ-ийн 2021 оны 05 дугаар тогтоолоор батлагдсан журмын I хавсралтын 4.1.2.3-т заасны дагуу хяналтыг хэрэгжүүлж 2021 онд улсын болон хувийн эмнэлэг, өрх, сумын ЭМТ, эмийн сангийн нийт 62 байгууллагын 175,849 иргэний 12,006.2 сая төгрөгийн төлбөрийн нэхэмжлэлийг хянан, 9,956 хүний 1,424.6 сая төгрөгийн санхүүжилтийг хасаж, 165.893 иргэний 10,581.7 сая төгрөгийн санхүүжилтийг олгосон, 2022 онд 255,852 хүний 19,560.9 сая төгрөгийн төлбөрийн нэхэмжлэлийг хянаж, 244,181 хүний 17,605.2 сая төгрөгийн санхүүжилтийг олгож, 11,671 хүний 1,955.7 сая төгрөгийн санхүүжилтийг хасаж олгосон байна.

Эмнэлэгт хэвтэн эмчлүүлсэн болон үзлэгт хамрагдсан тоон үзүүлэлт

Эмнэлгийн төрөл	2020 он		2021 он		2022 он	
	Эмнэлэгт хэвтсэн	Үзлэг	Эмнэлэгт хэвтсэн	Үзлэг	Эмнэлэгт хэвтсэн	Үзлэг
Аймгийн НЭ	7,496	108,154	10,170	112,771	8,980	150,860
Замын-Үүд НЭ	2,940	56,639	3,790	50,428	3,465	65,188
УАҮРСТ	945	3,469	957	2,142	1,201	2,283
Сумын ЭМТ	2,743	110,359	3,653	125,657	3,336	92,456
Өрхийн ЭМТ	-	85,447	-	121,233	-	103,593
Хувийн эмнэлгүүд	2,203	4,167	2,130	4,156	2,574	4,961
Эмийн сан	-	34,255	-	46,296	-	45,798
Нийт дүн	16,327	402,490	20,700	462,683	19,556	465,139

Гүйцэтгэлээр санхүүжилт олгосноор аймгийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж байгаа лавлагаа шатлалын 2 эрүүл мэндийн байгууллагын санхүүгийн үйл ажиллагааны үзүүлэлтэд нөлөөлсөн байдлыг авч үзэхэд дараах байдалтай байна.

Д/д	ЭМ-ийн тусламж үйлчилгээ үзүүлэгч байгууллагын нэр	Аймгийн НЭ		Замын-Үүд НЭ	
	Хамрагдах хугацаа	2021 он	2022 он	2021 он	2022 он
1	Нийт нэмэгдсэн ҮХ-ийн дүн	2,062.8	3,072.2	9,795.9	3,134.0
2	Үүнээс: Төсвийн хөрөнгөөр худалдаж авсан дүн	102.3	489.8	67.9	465.6
3	Өглөгийн нийт дүн	1,018.1	1,585.6	-	-
4	Үүнээс: Эмийн өглөг	1,017.0	1,274.8	-	-
5	Тогтмол зардлын өглөг	-	199.3	-	-
6	Авлагын нийт дүн	2,622.6	42.1	967.4	3.5
7	Үүнээс: ЭМДС-ийн санхүүжилтийн авлага	2,597.8	-	967.4	0,0
8	Бусад авлага	24,8	42,1	0	3,5

ЭМДҮЗ-ийн 2022 оны 01 дүгээр тогтоолын хүрээнд ЭМД-аас үзүүлэх 16 багц тусламж, үйлчилгээг бүрэн үзүүлэхэд шаардлагатай эм, тариа, багаж болон бусад хэрэгслийн өртөг, үнийг шингээж өгсөн бөгөөд хамтын төлбөртэй оношоос бусад тохиолдолд даатгуулагчаас нэмэлт төлбөр авахгүйгээр зохицуулж, даатгуулагч-иргэд хэвтүүлэн эмчлүүлэх үедээ санхүүгийн болон бусад аливаа эрсдэлээс үл хамаарч тусламж, үйлчилгээг бүрэн авах нөхцөл бололцоо бүрдсэн боловч Замын-Үүд сумын Нэгдсэн эмнэлэгт 2021 онд 1, аймгийн Нэгдсэн эмнэлэгт 2022 онд 5 иргэн хэвтэн эмчлүүлэх хугацаандаа хувиасаа худалдан авсан эм, тарианы төлбөрийг тухайн эрүүл мэндийн байгууллагаас гаргуулахаар өргөдөл өгснийг шийдвэрлээгүй байгаа нь Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хуулийн 16.1 дэх заалттай нийцэхгүй байх тул зөрчлийг арилгах тухай албан шаардлага хүргүүлэхээр шийдвэрлэлээ.

ЭМДХ-ээс сар бүр хэрэгжүүлсэн төлбөрийн нэхэмжлэлийн хяналтаар аймгийн Нэгдсэн эмнэлгийн санхүүжилтээс 2021 онд нийт 1,049.7 сая, 2022 онд 1,100.4 сая төгрөг, Замын-Үүд сумын НЭ-ийн санхүүжилтээс 2021 онд 342.0 сая, 2022 онд 679.8 сая төгрөгийг тус тус хасаж санхүүжүүлсэн байна.


Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлж байгаа эрүүл мэндийн байгууллагуудын төлбөрийн нэхэмжлэл болон олгосон санхүүжилтийн мэдээллийг авч үзэхэд 2021 онд нийт 1,424.6 сая төгрөгийн хасагдлын 1,391.7 сая төгрөг буюу 97.7 хувийг аймгийн Нэгдсэн эмнэлэг болон Замын-Үүд сумын Нэгдсэн эмнэлгийн санхүүжилтийн хасагдал эзэлж байна.

ЭМДҮЗ-ийн 2022 оны 01 тогтоолоор батлагдсан журмын холбогдох заалтыг зөрчиж, эмч байцаагчийн хяналтаар 2022 онд 706.9 сая төгрөг, тусламж үйлчилгээг давхардуулж нэхэмжилснээс 2021 онд 43.5 сая төгрөг, 2022 онд 459.7 сая төгрөг, ЭМДШ дутуу төлсөн, программд иргэний регистрийн дугаар буруу оруулж нэхэмжилснээс 2021 онд 92.2 сая төгрөг, оношийн хамааралтай бүлгийг буруу шивснээс 2021 онд 155.3 сая төгрөг, ЭМДС-


аас зардлын төлбөрийг нь хариуцах эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний оношийн хамааралтай бүлгийн жагсаалт, төлбөрийн хэмжээг баримтлаагүй /жирэмсэн/ илүү нэхэмжилснээс 2021 онд 893.1 сая төгрөг, тусламж үйлчилгээний төрлөөр гэрээ байгуулаагүйгээс 2022 онд 181.6 сая төгрөгийг тус тус хасаж санхүүжүүлсэн байна.

Төлбөрийн нэхэмжлэлийн хяналтаар хасагдаж байгаа хасагдлын нийтлэг шалтгаануудыг бууруулах зорилгоор ЭМДХ-ээс эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлж байгаа гэрээ байгуулсан эрүүл мэндийн байгууллагуудад сургалт зохион байгуулж, арга зүйн зөвлөгөө өгч ажилласан боловч хасагдал буурахгүй, 2022 онд өмнөх оноос өссөн үзүүлэлттэй байна.

Нэхэмжлэлийн хяналтаар санхүүжилт хасагдаж байгаа нь дараах хүчин зүйлээс шалтгаалсан байна. Үүнд:



Дээрх хүчин зүйлүүдээс шалтгаалж эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлж байгаа байгууллагуудад дараах хүндрэлтэй нөхцөл байдал бий болдог байна.



ЭМДЕГ-ын 2022 оны А/139 “Журам шинэчлэн батлах тухай” тушаалаар батлагдсан нэхэмжлэлийг хянах журмаар нэхэмжлэлийн нарийвчилсан хяналтыг хийхдээ санамсаргүй болон зорилтот түүврийн аргуудыг ашиглаж тухайн ЭМБ-ын сонгогдсон тусламж үйлчилгээний түүврийг нарийвчилсан хяналтын шалгуур ашиглан гүйцэтгэж байгаа ба нэхэмжлэлээр ирүүлсэн үйлчилгээнээс эх олонлогийг төлөөлөх түүврийг сонгож, тухайн түүврээс зөрчилтэй гарсан оношийн бүлгийн тодорхой хувийг зөрчилгүй

байсан ч автоматаар хасалт хийж санхүүжилтийг бууруулж байгаа нь дээрх журамд заасан даатгуулагчийн эрх ашгийг дээдлэх зарчим болон ЭМДТХ-д заасан гүйцэтгэлд суурилсан санхүүжилт олгох арга хэлбэрийн гол зарчим алдагдаж байгаа зөрчилд аймгийн Нэгдсэн эмнэлэг, Замын-Үүд сумын нэгдсэн эмнэлэгт албан шаардлага хүргүүлэхээр шийдвэрлэлээ.

ДҮГНЭЛТ: Аудитын явцад цуглуулсан нотлох зүйлс, аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлтийг өгсөн. Үүнд:

- ЭМДС-ийн 2022 оны орлогын төлөвлөгөөг төлөвлөхдөө хамралтыг 19.3 хувиар бууруулж, орлогыг өмнөх оны гүйцэтгэлийг 101.7 хувиар тооцоо судалгаагүй нэмэгдүүлснээс сангийн орлогын төлөвлөгөө 4,465.7 сая төгрөгөөр тасарсан байна.
- Эрүүл мэндийн тусламж үйлчилгээнд хамрагдаж чадахгүй байгаа эмзэг бүлгийн иргэдийн талаар нэгдсэн судалгаа байхгүй, тэднийг эмнэлгийн тусламж үйлчилгээнд хамруулах талаар ЭМГ, ЭМ-ийн байгууллагууд үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгаагүй, энэ талаар арга хэмжээ авч ажиллаагүй байна.
- Аймгийн хөгжлийн бодлогын баримт бичгийн хэрэгжилтэд ЗДТГ-ын Хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтэс хяналт-шинжилгээ хийхдээ хэрэгжүүлсэн зорилт, арга хэмжээний үр дүн, тоо баримт, судалгаа, шинжилгээнд үндэслэсэн байх зарчмыг баримтлаагүй, өмнө онд хийгдсэн ажлыг дахин үнэлсэн байна.
- Эрүүл мэндийн салбарын мэргэжлийн боловсон хүчний дутагдалтай байдлаас шалтгаалан аймгийн ЭМДХ нь батлагдсан бүтэц орон тоогоор ажиллаагүйгээс ЭМДХ-ийн чанар болон төлбөрийн нэхэмжлэлд хяналт хийх чиг үүрэг хязгаарлагдсан байна.
- Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэгч байгууллагуудтай даатгалын гэрээг журмын дагуу байгуулсан ч лавлагаа болон анхан шатны тусламж үйлчилгээ үзүүлэгч байгууллагын 2022 оны гэрээг дүгнээгүй байна.
- Дорноговь аймгийн ЭМДХ-ийн цахим болон нарийвчилсан хяналтаар аймгийн Нэгдсэн эмнэлгийн төлбөрийн нэхэмжлэлээс 2021 онд 1,049.7 сая төгрөг, 2022 онд 1,100.4 сая төгрөгийн, Замын-Үүд сумын Нэгдсэн эмнэлгийн төлбөрийн нэхэмжлэлээс 2021 онд 342.0 сая төгрөг, 2022 онд 679.8 сая төгрөг, аудитад хамрагдсан хугацаанд нийт 3,171.9 сая төгрөгийн санхүүжилтийг хасаж олгосон байна.
- Иргэдийн хувиасаа гаргасан эмийн зардлыг гаргуулахаар хүсэлт гаргасан өргөдөл гомдлыг шийдвэрлээгүй байна.
- ЭМДС-ийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа Health.gov.mn программын хөгжүүлэлтийг сайжруулах шаардлагатай байна.
- Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн 4.2 дахь заалт, Нийгмийн даатгалын тухай хуулийн 4.3 дахь заалтуудын нийцлийг хангаж, сайн дурын даатгал төлөгчдийг ЭМДШ-д хамруулснаар ЭМДС-ийн эх үүсвэрийг нэмэгдүүлэх боломж байна.

Аудитаар нийт 6 зөрчил илрүүлж, зөрчил арилгах тухай 4 албан шаардлага, алдааг давтан гаргахгүй байх талаар холбогдох албан тушаалтанд 2 зөвлөмж хүргүүлэхээр шийдвэрлэлээ.

ЗӨВЛӨМЖ:

Аудитын дүн, дүгнэлт, нотлох зүйлст үндэслэн дараах зөвлөмжийг өгч байна. Үүнд:

АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН ДАРГА Н.ХОНГОРЗУЛ ТАНАА:

1. Аймгийн хөгжлийн бодлогын баримт бичгийн хэрэгжилтэд Хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтэс үнэлгээ хийхдээ Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор баталсан "Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл

ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам"-ын 3.1.3, 7.3-т заасны дагуу тоо баримт, судалгаа, шинжилгээнд үндэслэсэн байх зарчмыг баримтлан урьдчилан тодорхойлсон шалгуур үзүүлэлтэд үндэслэн хяналт-шинжилгээ, үнэлгээг хийх.

ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗРЫН ДАРГЫН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ Д.БАТЦЭЦЭГ ТАНАА:

1. Эрүүл мэндийн тусламж үйлчилгээнд хамрагдаж чадахгүй байгаа эмзэг бүлгийн иргэдийн судалгааг аймгийн дүнгээр гаргаж, тэднийг эмнэлгийн тусламж үйлчилгээнд хамруулах талаар байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгаж, хэрэгжүүлэх.

САНАЛ:

Аудитын дүн дүгнэлтэд үндэслэн УАГ-т болон УАГ-аар дамжуулан ЭМДЕГ-т дараах саналыг хүргүүлж байна.

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАРТ :

1. Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн 4.2-т “Монгол Улсын иргэн эрүүл мэндийн улмаас учирч болзошгүй санхүүгийн эрсдэлээ хуваалцах зорилгоор эрүүл мэндийн албан журмын даатгалд заавал даатгуулна”, Нийгмийн даатгалын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 3-т “Энэ хуулийн 4 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт зааснаас бусад тодорхой хөдөлмөр эрхлээгүй Монгол Улсын иргэн, гадаадын иргэн, харьяалалгүй хүн энэ хуульд заасан болзол, журмын дагуу энэ хуулийн 3 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн 1/тэтгэврийн даатгал/, 2/тэтгэмжийн даатгал/, 4/ҮОМШӨ-ний даатгал/ дэх заалтад дурдсан даатгалд сайн дураар даатгуулж болно. Сайн дураар даатгуулагч нь дээр дурдсан нийгмийн даатгалын төрөл тус бүрд хамрагдана” гэсэн заалтууд нийцэхгүй байна. Иймд НДТХ-ийн 4.3 дахь заалтад сайн дурын даатгалд даатгуулсан иргэдийг ЭМДШ-д хамруулах өөрчлөлт оруулснаар ЭМДС-ийн эх үүсвэр нэмэгдэх боломж байна.

ЭРҮҮЛ МЭНДИЙН ДААТГАЛЫН ЕРӨНХИЙ ГАЗАРТ:

1. Эрүүл мэндийн даатгалын сангийн орлогыг өмнөх жилийн төлөвлөгөө, гүйцэтгэл болон бусад холбоотой тоон үзүүлэлттэй уялдуулан төлөвлөж, Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн 16.1.2-т заасан чиг үүргийг хэрэгжүүлж ажиллах.
2. Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн 16.1.18-д заасан чиг үүргийг хэрэгжүүлж аймгийн ЭМДХ-ийн хүний нөөцийн асуудлыг шийдвэрлэж, ажилтнуудын ачааллыг тэнцвэржүүлэх, үндсэн чиг үүргээ хэрэгжүүлэх нөхцөлөөр хангах.
3. Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэгч лавлагаа болон анхан шатны ЭМБ-уудтай байгуулсан даатгалын гэрээг журамд заасан хугацаанд дүгнэж, Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн 16.1.3-т заасан гэрээний биелэлтэд хяналт тавих.
4. Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн 16.1.8-д заасан чиг үүргийг хэрэгжүүлж, эрүүл мэндийн даатгалын үйлчилгээнд ашиглаж байгаа программ хангамжийн уялдааг хангах, хөгжүүлэлт хийх, ашиглалтыг сайжруулах.
5. Эрүүл мэндийн байгууллагуудтай байгуулсан эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ худалдан авах гэрээ болон санхүүжилт олгосон ажил гүйлгээг Шилэн дансны тухай хуулийн 6.4.5, 6.4.8-д заасан хугацаанд байршуулах.